



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 06 өдөр

Дугаар №38

Далгэрхаан сум

Цэрэг татлага зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2025 оны мн/148 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны мн/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт Соёлын төвд зохион байгуулсугай.

2. Цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга:

Д.Урангоо

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ш.Цэрэндулам

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

О.Батбаяр

(Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)

Н.Доржнамжил

(Соёлын төвийн дарга)

П.Буянтогтох

(Хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад)

Б.Энхцэцэг

(Хэрлэнбаян-Улаан тосгоны захирагч)

Б.Бүжинлхам

(2-р багийн Засаг дарга)

Б.Мөнхболд

(3-р багийн Засаг дарга)

Д.Оюунчимэг

(4-р багийн Засаг дарга)

Г.Батнасан

2326010076

(5-р багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.Золзаяа

(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн судалгааг үндэслэн эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгууулах, цэрэг татлагын товчооны байранд эрүүл мэндийн үзлэг хийх бэлтгэл ажлыг хангахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (О.Батбаяр)-т, цэргийн албанд татагдах залуучуудын боловсролын түвшинг тогтоох, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг албан бус сургалтанд хамруулахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ш.Цэрэндулам)-д, цэргийн албанд татагдах залуучуудын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, цэрэг тээвэрлэх авто машинд үзлэг хийх, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад (П.Буянтогтох), цэрэг татлагын байрны галын аюулгүй байдлыг хангах, цэрэг татлагын товчооны зохион байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэхийг Соёлын төвийн дарга (Н.Доржнамжил), цэргийн албанд татагчдын өргөдөл, материалыг бүрдүүлж, судалгаа гаргахыг Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн бөгөөд цэрэг татлагын товчооны нарийн бичиг (Ц.Золзаяа) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлж заасан хугацаанд цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг шинэчлэн бүрдүүлж бүрэн хамруулах, цэргийн албанд тэнцсэн залуучуудыг цусны бүлэг тогтоох, шээсний шинжилгээг хийлгэсэн байх, цэргийн албанд татагчдыг үдэж мордуулах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авч тэднийг ажлын байранд жуучлахыг 1,2,3,4,5 дугаар багийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Цэргийн албанд тэнцсэн залуучуудын бичиг баримтыг бүрдүүлж, цэргийн албанаас халагдаж ирсэн залуучуудыг хүлээн авч, цэргийн бүртгэлд тусгаж багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгөхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

